МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ХОЛБОО
мэргэжлийн төрийн бус байгууллага

МУИС-ийн профессор, БОАХ-ны гүйцэтгэх захирал
О.Алтансүх

БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН БОЛОВСОН ХҮЧНИЙ БОДЛОГО, ХЭРЭГЖИЛТ, ХҮНИЙ НӨӨЦ

Эрдэнэтийн УБҮ дэх байгаль орчны аудитын практик сургалт
2017-08-29

Эрх зүй

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А-126 дугаар тушаалын хавсралтууд “БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТ ХИЙХ ЭРХ ОЛГОХ ЖУРАМ”, “БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТ ХИЙХ ЕРӨНХИЙ АРГАЧЛАЛ”

Журмын 4.1 заалт:

БОАЖЯ ⇨ МУИС + БОАХ



Улсын нэгдсэн бүртгэлийн 2013 оны 06 р
сарын 04-ны өдрийн 3383 дугаарт бүртгэв.
Монгол Улсын Хууль зүйн яам

МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН
САЙДЫН ТУШААЛ

2013 оны 4 сарын 24 өдөр Дугаар А-126 Улаанбаатар хот

“Журам батлах тухай”

“Байгаль орчныг хамгаалах тухай хууль”-ийн 10^1 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ НЬ:

1.Байгаль орчны аудит хийх эрх олгох журмыг 1 дүгээр, байгаль орчны аудит хийх аргачлалыг 2 дугаар, байгаль орчны аудит хийх эрхийн гэрчилгээний загварыг 3 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

Дөрөв. Бусад

4.1. Байгаль орчны аудит хийх эрх олгосон бодовсон хүчнийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай энэ чиглэлээр хамтран ажилах гэрээ байгуулсан эрх бүхий сургалтын байгууллага бэлтгэнэ.

Зохион байгуулалт

Сургалтыг захиалагч:

- Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам



Сургалтыг зохион байгуулагч:

- Монгол Улсын Их Сургууль

Багшлах боловсон хүчин:

- “Байгаль орчны аудитын холбоо” мэргэжлийн төрийн бус байгууллага

Сургалтын зорилго:

- БОНХ-ийн Сайдын 2013 оны А-126 тоот тушаалын 1-р хавсралт “Байгаль орчны аудит хийх эрх олгох журам”-ын 4.1 заалтыг хангах, байгаль орчин, хууль эрх зүй, технологийн мэргэжилтнүүдэд аудитын мэдлэг, ур чадвар олгох замаар байгаль орчны аудитор бэлтгэх зорилготой.



Сургалтын хугацаа:

- 15 хоног

Онцлог

Сургалтын хэлбэр

Сургалтыг лекц, семинар, илтгэл, хэлэлцүүлэг, дасгал ажил, нөхцөлт бодлого, туршилтын аудит гэсэн олон хэлбэрийг хослуулан явуулна. Лекцийн хичээлийн үед авсан мэдлэгийг семинарын хичээл дээр шууд практик бодит жишээгээр шийдвэрлэх замаар бататгана. Танхимын сургалт дууссаны дараа сонгон авсан объектод хээрийн судалгаагаар аудит хийж, дүгнэлт гарган үл нийцлийг арилгах төлөвлөгөөг боловсруулна. Сургалтын төлөвлөгөө нь аудитын процесс руу чиглэсэн бөгөөд суралцагсад нь байгаль орчны аудитын үйл ажиллагааны үед шаардагдах мэдлэг, чадварыг эзэмшинэ. Сургалт нь оролцооны аргад тулгуурлах ба аудитын ур чадвар, мэдлэгийг эзэмшихийн тулд суралцагч бүр сургалтын туршид хичээлд идэвхтэй оролцох шаардлагатай. Аудитын онолын, хууль эрх зүйн болон практик ур чадвар бүхий үндэсний эрдэмтэд багшилна.

Сургалтын онцлог

- Сургалтад хамрагдаж, шаардлагуудыг хангаснаар байгаль орчны аудитор болох эрх нээгдэнэ.
- Танхимын сургалт оролцооны аргад суурилна.
- Практик давамгайлсан албан бус сургалт хэлбэрээр явагдана.

Дадлага ажил:

Сургалтын төгсгөлд туршилтын аудитыг сонгосон объектод хийх бөгөөд энд аудитын бүх үе шатууд хийгдэнэ.

Тавигдах шаардлага

Тавигдах шаардлага

- Хууль эрх зүй, экологи, байгаль орчин, байгаль хамгаалал, технологи чиглэлийн мэргэжилтэй
- Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан
- Судалгаа шинжилгээний ажлын туршлагатай мэргэшсэн боловсон хүчин байна.

Сургалтын гэрээ:
Сургалтад оролцогч болон зохион байгуулагч талуудын хооронд сургалтын гэрээ байгуулах бөгөөд ингэснээр сургалтад хамрагдах эрх үүснэ.

Сургалтын төлбөр:
МУИС-ийн Удирдах Зөвлөлийн жил бүр оюутны сургалтын төлбөрийг баталдаг бөгөөд энэ нь аудитын сургалтын төлбөрийг тогтоох үндэслэл болдог.

Шалгалт ба гэрчилгээ:
БО-ы аудитор болохын тулд сургалтын эцэст мэргэжлийн шалгалт өгч, 80%-аас дээш үнэлгээ авах шаардлагатай. Байгаль орчны аудиторын гэрчилгээг МУИС+БОАЖЯ-аас хамтран олгоно. Сургалтын ирц 80% хүрээгүй, шалгалтад тэнцээгүй, журмын шаардлага хангаагүй, сургалтын төлбөр бүрэн төлөөгүй тохиолдолд аудиторын гэрчилгээг олгохгүй.

Кредит цаг:
Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан нийт 120 цаг буюу 7200 минутын сургалтыг академик цаг руу хөрвүүлбэл 160 цаг болно. 1 кредит цаг нь 16 академик цагтай тэнцдэг тул нийт сургалтын кредит цаг нь 10 болно. Академик цаг гэдэг нь 45 минуттай тэнцдэг.

Сургалтын төлбөр

БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН СУРГАЛТЫН ТӨЛБӨР

БОНХАЖЯ, МУИС-ийн хамтран ажиллах гэрээний 2.2.4 болон МУИС-ийн Удирдах Зөвлөлийн 2015 оны 05-р тогтоолын 1-р хавсралтыг үндэслэн байгаль орчны аудитын сургалтын төлбөрийг дараах байдлаар тогтоов.

Байгаль орчны аудит хичээл нь ХШУИС-д хамаарах тул тогтоолд зааснаар 2015-2016 оны хичээлийн жилийн бакалаврын түвшний сургалтын төлбөр нь ХШУИС-ийн хувьд суурь хураамж 224000 төгрөг, нэг багц цагийн төлбөр нь 80200 төгрөг байна.

Кредит цаг:
Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан нийт 120 цаг буюу 7200 минутын сургалтыг академик цаг[1] руу хөрвүүлбэл 160 цаг болно. 1 кредит цаг нь 16 академик цагтай тэнцдэг тул нийт сургалтын кредит цаг нь 10 болно.

Сургалтын төлбөр:
Сургалтын төлбөрийг тогтоохдоо нийт сургалтын 10 кредитээр бус сургалт танхимын зохион байгуулалтаар явагдаж буй 6,3 кредит цагаар тооцов.

80200 ₮ * 6,3 кредит = 505260 + 224000 = 729260 төгрөг

Уг төлбөрт дараах багц зардлууд багтсан. Үүнд:

1. Бэлтгэл үйл ажиллагаа: Зар түгээлт, бүртгэл, анонс хэвлэлт, мэдээ материал цуглуулах гэх мэт
2. Сурах орчин: Хичээлийн анги танхим, багаж тоног төхөөрөмж, цахилгаан, дулаан гэх мэт
3. Багшлах боловсон хүчин: Цалин, тээврийн зардал гэх мэт
4. Сургалтын материал: Бал, дэвтэр, DVD, хууль эрх зүй, дүрэм журам, стандартын багц, ном, гарын авлага гэх мэт
5. Хангамж: Цай, кофе, печень, нэг удаагийн аяга, халбага гэх мэт
6. Хаалтын ажиллагаа: Шалгалт, гэрчилгээ гардуулалт, тайлан гэх мэт

Багц цагийн төлбөрөөс гадна дээрх зардлууд төлөвлөгдсөн тул суурь хураамжийг бүтнээр тооцох нь зүйтэй.

Нягтлан бодогч Б.Бадамханд

[1] Академик цаг гэдэг нь 45 минуттай тэнцдэг.

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 06 сарын 03 өдөр Дугаар 05 Улаанбаатар хот

Сургалтын төлбөр, дотуур байрны үйлчилгээний төлбөрийн хэмжээ тогтоох тухай

Боловсролын тухай хуулийн 36 д
Улсын Их Сургуулийн Удирдах зөвлө
хуралдааны тэмдэглэлийг үндэслэн ТО

1. Сургуулийн 2015-2016 оны хи
багц цагийн төлбөрийг нэгдүг
цагийн төлбөрийг хоёрдугаар,
оюутны дотуур байрны үйлчи
тус тус тогтоосугай.

2. Сургуулийн оюутны дотуур
/зургаан зуун гучин мянга/ төгр

3. Төлбөрийн хэмжээ тогтоосонтой холбогдуулан сургуулийн 2015 оны төсөвт тодотгол хийх асуудлыг судлан боловсруулж, 2015 оны 09-р сарын 01-ны дотор Удирдах зөвлөлд танилцуулахыг захирал /Р.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

ДАРГА Б.НАСАНБАЯР

СУРГАЛТЫН ГЭРЭЭ БА ТӨЛБӨР

Шалгаруулалтад тэнцсэн хүмүүс сургалтын төлбөр болох 729260 ₮-ийг Монгол Улсын Их Сургуулийн тоот дансанд тушаагаад, баримтаа авчран, сургалтын гэрээ байгуулна. Сургалтын төлбөр төлөхийн өмнө сургалтын гэрээг **ЗААВАЛ** уншиж танилцана уу.

Хүлээн авагч банк: ХААН банк
Хүлээн авагчийн нэр: Монгол Улсын Их Сургууль
Дансны төрөл: Төгрөг
Дансны дугаар: 504 112 3745
Гүйлгээний утга: БОА-ын сургалтын төлбөр, овог нэр

Сургалтын гэрээг МУИС-ийн хичээлийн 3-р байрны 313 тоот өрөөнд 2015 оны 10-р сарын 14-15-ны өдрүүдийн 11^{00}-16^{00} цагийн хооронд хийх ба сургалт 16-ны өдрийн 09 цагаас эхлэн ХААИС-ийн замын эсрэг талд Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвд явагдана.

Сургалтын схемчилсэн дараалал

Байгаль орчны аудитын сургалтын агуулгын схемчилсэн дараалал



Сургалтын хөтөлбөр танилцуулах

Аудиторын эрх олгох шалгалт нь үндсэн хоёр хэсгээс бүрдэнэ:

Онол-эрхзүй	60%
Практик ур чадвар	40%

Онол-эрхзүйн шалгалт нь нийт үнэлгээний 60%-ийг эзлэх ба шалгалтыг МУИС авна. Практик ур чадварын шалгалт нь сургалтын явцад хийгдсэн дадлага ажлын тайлангаар тооцогдох ба энэ нь үнэлгээний 40%-тай тэнцэнэ. Нийлбэр оноогоор 80%-иас дээш үнэлгээтэй бол аудиторын гэрчилгээ авах эрх үүснэ. Нийт оноо 80% хүрээгүй тохиолдолд аудиторын эрх үүсэхгүй бөгөөд дахин шалгалт өгөх шаардлагатай. БОАЖЯ, МУИС, БОАХ, аудит хийлгэгч компанийн төлөөлөл оролцсон 5-7 хүний бүрэлдэхүүнтэй шалгалтын комисс үнэлгээг өгнө.

Сургалтын гэрээ

БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТОР БЭЛТГЭХ ГҮНЗГИЙРҮҮЛСЭН ШАТНЫ ДӨРӨВ ДЭХ УДААГИЙН СУРГАЛТЫН ГЭРЭЭ

2015 оны 10 сарын 15 өдөр *Дугаар 15/...* *Улаанбаатар хот*

Энэхүү гэрээг нэг талаас Сургалт зохион байгуулагч тал, түүнийг төлөөлж сургалтын зохицуулагч О.Алтансүх, нөгөө талаас сургалтад хамрагдахыг хүсэгч ..... регистрийн дугаартай ..... овогтой ..... (цаашид "Суралцагч" гэх) нарын байгаль орчны аудитын сургалтыг чанартай зохион байгуулах, мэргэжлийн багшлах бүрэлдэхүүнээр хичээл заалгах, сургалтын орчныг бүрдүүлэх, шалгалт авах, гэрчилгээ олгох, суралцагч талаас сургалтад бүрэн хамрагдаж, холбогдох шалгуурыг хангаснаар байгаль орчны аудиторын эрх авахтай холбоотой талуудын дунд үүсэх харилцааг зохицуулахаар дор дурдсан нөхцөлөөр байгуулав.

Нэг: Ерөнхий зүйл

1.1. "Сургалт зохион байгуулагч тал" гэдгийг Байгаль Орчин, Ногоон Хөгжил, Аялал Жуулчлалын Яамтай хамтран ажиллах гэрээ хийсэн Монгол Улсын Их Сургууль (цаашид "МУИС" гэх)-ийг ойлгоно.

1.2. Сургалт нь нийт 10 кредит цаг байна.

1.3. Сургалтын хугацаа нь 2015 оны 10 сарын 16-наас 2015 оны 10 сарын 30 хүртэл байна.

1.4. Талууд гэрээнд гарын үсэг зурснаар гэрээ хүчин төгөлдөр болж, суралцагчийн сургалтад суух эрх нээгдэнэ. Суралцагч гэрээнд гарын үсэг зурсан нь уг гэрээний нөхцөлийг хүлээн зөвшөөрсөнд тооцогдоно.

Хоёр: Сургалт зохион байгуулагч талын эрх үүрэг

2.1. Сургалт зохион байгуулагч тал нь дараах эрх, үүрэгтэй. Үүнд:

2.1.1. Сургалтын нээлт, хаалтыг ажиллагаар зохион байгуулах;

2.1.2. Сургалт явагдах анги танхим, багшлах боловсон хүчин, ном сурах бичиг гэх мэт сурах орчноор хангах;

2.1.3. Сургалтын бүртгэл, сонгон шалгаруулалтыг БОНХАЖЯ-тай хамтран зохион байгуулах;

2.1.4. Сургалтын нийт ирц 80% хүрээгүй, сургалтын төлбөрийг бүрэн төлөөгүй, сургалтын явцад олгосон гарын авлага, холбогдох материал, эд зүйлсийг буцааж өгөлгүй завшсан суралцагчийг шалгалтад оруулахгүй байх;

2.1.5. Сургалтын явцад суралцагч талаас гарсан санал хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэх;

2.1.6. Сургалтын төгсгөлд мэргэжлийн шалгалтыг зохион байгуулж, дүнг боловсруулан гаргах, түүнийгээ суралцагч болон БОНХАЖЯ-нд мэдэгдэх;

2.1.7. Шалгалтын дүнг үндэслэн байгаль орчны аудиторын гэрчилгээг шалгалтад тэнцсэн суралцагчдад олгох ажлыг зохион байгуулах;

Гурав: Суралцагчийн эрх үүрэг

3.1. Суралцагч нь дараах эрх, үүрэгтэй. Үүнд:

3.1.1. Сургалтын нээлт, хаалтын ажиллагаанд оролцох;

3.1.2. Сурах орчин, ном сурах бичгээр хангагдах;

3.1.3. Сургалтын төлбөрийг бүрэн төлөх;

3.1.4. Сургалтын ирц бүрдэж, энэ гэрээний 5.1, 5.2-т заасныг зөрчөөгүй тохиолдолд сургалтын төгсгөлд шалгалтад орж, дүгнүүлэх;

3.1.5. Хичээлийн ирц 80% ба түүнээс дээш бүрдэж, шалгалтад 80 ба түүнээс дээш оноо авсан, мөн БОНХ-ийн Сайдын 2013 оны А-126 тоот тушаалаар батлагдсан Байгаль орчны аудит хийх эрх олгох журмын шаардлага хангасан тохиолдолд гэрчилгээ авах;

3.1.6. Сургалтын төлөвлөгөө, агуулга, багшлах боловсон хүчний талаар МУИС-д санал хүсэлт гаргах;

3.1.7. Шалгалтад тэнцээгүй тохиолдолд дараагийн сургалтын шалгалтад тухайн жилийн төлбөрийн 10%-тай тэнцэх төлбөрийг төлж, шалгалтад дахин хамрагдах;

3.1.8. Сургалтын үед тараасан стандарт, гарын авлага, хуулийн эмхэтгэл зэргийг авч явахгүй байх, шаардлагатай тохиолдолд хариуцаж буй зохион байгуулагчид бүртгүүлэх;

Дөрөв: Сургалтын төлбөр ба хөнгөлөлт, шалгалтын нөхцөл

4.1. Сургалтын төлбөр тухайн жилийн МУИС-ийн 1 кредит цагийн үнэлгээ ба суурь хураамжтай уялдан тогтоогдоно.

4.2. Сургалтын төлбөрийг бүрэн барагдуулснаар шалгалтад орох эрх нээгдэнэ.

4.3. Сургалтын хугацаа 14 ба түүнээс дээш хоног үргэлжлэх бөгөөд амралтын өдөр, давагдашгүй нөхцөл байдал, дээд удирдлагын шийдвэр, гэнэтийн өөрчлөлтөөс улбаалан дундаа завсарлагатай байж болно.

4.4. Суралцагч нь сургалтад онол-эрхзүйн, хээрийн сургалтын, шалгалтын гэсэн хэсгүүдэд хэсэгчлэн хамрагдаж болох бөгөөд сургалтад хамрагдахдаа тухайн төлбөрийг харгалзуулан төлнө. Энэ нь зөвхөн сургалтын хөтөлбөрийн 20%-иас багагүй хэсэг нь өөрчлөгдсөн тохиолдолд хүчинтэй. Сургалтын хөтөлбөр түүнээс дээш хувиар өөрчлөгдсөн тохиолдолд сургалт зохион байгуулагч талын шийдвэрээр үргэлжлүүлэн суралцах эсэх нь шийдэгдэнэ. Энэ тухай албан тодорхойлолтыг сургалт зохион байгуулагч талаас гаргаж өгнө.

4.5. Суралцагчийн ирц бүрдээгүй, шалгалтад тэнцээгүй, Байгаль орчны аудит хийх эрх олгох журмын шаардлага хангаагүй тохиолдолд аудиторын гэрчилгээг олгохгүй бөгөөд сургалтын төлбөрийг буцаан олгохгүй.

Тав: Гэрээний хариуцлага

5.1. Хичээлийн явцад саад болсон, багш нартай хүндэтгэлгүй харьцсан, маргалдсан, зүй бус шаардлага тавьсан суралцагчийг сургалт зохион байгуулагч тал сургалтаас хасах эрхтэй.

5.2. Сургалтын ирц бүрдээгүй, анхан шатны бүртгэлд хамрагдаагүй, мэргэжлийн шалгуур хангаагүй (бакалаврын дипломоор нотлогдоно), ажилласан жил хүрээгүй (нийгмийн даатгалын дэвтрээр нотлогдоно), сургалтын төлбөрөө бүрэн төлөөгүй суралцагчийг шалгалтад оруулахгүй.

5.3. Шалгалтын явцыг дүрс бичлэгээр баталгаажуулах бөгөөд 2 ба түүнээс дээш удаа бусдад садаа болох, хуулбарлахыг оролдох, гар утас болон бусад техник тоног төхөөрөмж ашигласан тохиолдолд шалгалтын дүнг хүчингүйд тооцох ба 3.1.7-д заасан эрх хамаарахгүй болно.

Зургаа: Бусад

6.1. Танхимын сургалтын үеийн тээврийн хөлс, өдрийн хоол болон эрүүл мэнд, эд хөрөнгийн даатгалын асуудлыг суралцагч өөрөө хариуцах ба үүнтэй холбогдон гарах асуудлыг сургалт зохион байгуулагч тал хариуцахгүй.

6.2. Сургалтын хөтөлберт тусгагдсан хичээлүүд гаднаас уригдан зааж буй багш нарын хүсэлтээр өөрчлөгдөх магадлалтай.

6.3. Хээрийн сургалтын үеэр зөвхөн сургалт зохион байгуулагчдын зүгээс гаргасан авто тээврийн хэрэгслээр зорчих бөгөөд нэг сая хүртэлх үнэлгээтэй гэнэтийн ослын даатгалыг сургалтыг зохион байгуулагч тал, эд хөрөнгийн даатгалыг суралцагч хариуцна.

6.4. Хээрийн сургалт зохион байгуулагдаж буй газарт очоод, тухайн байгууллагын аюулгүй ажиллагаатай танилцаж, дагаж мөрдөнө.

6.5. Хээрийн дадлага хийж буй объекттой танилцах үед талбайн аль хэсэгт ажиллах гэж байгаагаа хариуцаж буй зохион байгуулагчид мэдээлж, зөвшөөрөл авна.

6.6. Сургалтын хугацаанд архи, согтуурууллах ундаа хэрэглэхийг хатуу хориглох бөгөөд хэрэглэсэн тохиолдолд сургалтад үргэлжлүүлэн оролцуулахгүй ба сургалтын төлбөрийг буцаан олгохгүй.

6.7. Энэхүү гэрээ нь аудиторын гэрчилгээ авснаар, мөн тодорхой шалгааны улмаас сургалтыг үргэлжлүүлэх боломжгүй болох, дараагийн сургалтад суралцах тодорхойлолт сургалт зохион байгуулагч талаас авснаар дуусгавар болно.

МУИС-ийн төлөөлж:
Сургалтын зохицуулагч
доктор О.Алтансүх

Суралцагч: .....
..... овогтой .....

Шалгалт ба дараагийн сургалт



Хэрэглэгдэхүүн:

- Барын харандаа
- Баллуур
- Шалгах машин
- Шалгалтын хуудас

NAME _____

SUBJECT _____

DATE _____ PERIOD _____

Шалгалтын хуудас:

~ NAME	Овог, нэрээ бичнэ
~ SUBJECT	БОА-ын сургалт
~ DATE	он, сар, өдөр
~ PERIOD	60 минут

Зөв гэж бодсон нэг болон олон хариултыг зөвхөн өгөгдсөн харандаагаар өгөгдсөн талбайг дүүртэлд будах бөгөөд ариолгах бол баллуур ашиглана. Баллаж цохолсон тохиолдолд буруу гэж машинд уншигдана.

Дараагийн сургалтын болзол:

- Ирц 80% ба түүнээс дээш
- Шалгалт 80 ба түүнээс дээш
- Журмын шаардлага



Гэрчилгээ



БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН ЯАМ

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТОРЫН ГЭРЧИЛГЭЭ

№2014/067

Юнгэр овогтой Дэлгэрмаа нь

РД: УК64112301

“Байгаль орчны аудит хийх эрх олгох журам”-ын дагуу Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, Монгол Улсын Их Сургуулийн хамтран зохион байгуулсан “Байгаль орчны аудитор бэлтгэх гүнзгийрүүлсэн хоёрдугаар сургалт”-ыг амжилттай дүүргэсэн тул шалгалтын комиссын нэгдсэн дүнг үндэслэн БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТОР-ын гэрчилгээ олгов.

Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга

Доктор Ж.БАТБОЛД

Монгол Улсын Их Сургуулийн Захирал

Доктор А.ГАЛТБАЯР

Улаанбаатар хот

2014-06-09

БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН ЯАМ
МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

2014/067 тоот гэрчилгээний хавсралт

“Байгаль орчны аудитор бэлтгэх гүнзгийрүүлсэн хоёрдугаар сургалт”-д хамрагдаж, дараах агуулга бүхий сургалтын хөтөлбөрийг дүүргэсэн болно.

СУРГАЛТЫН АГУУЛГА:

- БОА-ын тодорхойлолт, ухагдахуун, хэрэгцээ шаардлага
- БОА-ын эрх зүй
- БОА-ын олон улсын туршлага, цаашдын хандлага
- БО-д учруулсан хохирлууд ба БОА-аар урьдчилан сэргийлэх боломж
- Монгол Улсын нэгдэн орсон БО-ны олон улсын гэрээ хэлэлцээр
- Монгол Улсын байгаль орчны эрх зүйн орчин
- БОНБҮ-ний хууль эрх зүйн орчин
- Аудиторын ёс зүй
- Байгаль орчны стандарт, хэм хэмжээ
- БОА-ын онцлог, ач холбогдол
- БОА-ын төрлүүд
- БОА-ын баг бүрдүүлэлт, удирдагч сонголт
- БОА-ын процесс, баримт бүрдүүлэлт
- БОА-ын дотоод арга зүй боловсруулалт
- Монгол Улсад хийгдэж байсан БОА-ын ажлын туршлага
- БОА-ын аргачлал
- БОА-ын үйл ажиллагаа
- Аудитын бэлтгэл үе шат
- Хууль эрх зүйн шалгах жагсаалт
- Асуулгын шалгах жагсаалт
- БОА-ын тайлан дүгнэлт, зөвлөмж, боловсруулалт
- Аудитын мөрөөр эргэж шалгалт
- БОА-ын хязгаарлалт
- Байгууллагын экологийн хариуцлагын гэрээ

Гэрчилгээгүй бол хүчингүй.

НИЙТ: 10 кредит цаг

ААН ба хүний нөөц

2013 оноос хойш өнөөг хүртэл 4 удаагийн сургалтаар нийт 164 үндэсний аудитор бэлтгэгдсэн бөгөөд 25 компани журмын шаардлагыг хангаж, байгаль орчны аудит хийх эрхийг БОАЖЯ-аас авсан.


МОНГОЛ УЛС
БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

ЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТ ХИЙХ ЭРХИЙН

ГЭРЧИЛГЭЭ

Мэргэжил - BSc

Ажилласан жил – 5 эсвэл 8

Мэргэшсэн байдал – MSc эсвэл PhD

Сургалт – Гэрчилгээ | Сургалт – Гэрчилгээ | Сургалт – Гэрчилгээ | Сургалт – Гэрчилгээ | Мэргэжилтэн | Мэргэжилтэн

ААН

Тусгай зөвшөөрөл

Аудит - Аргачлал | Эксперт

Хууль тогтоомж | Төрийн бодлого | Үндэсний хөтөлбөр | БОНБҮ | Стандарт

Дүгнэлт, зөвлөмж

Захиалагч

Үүрэг амлалт

Биелэлтийн тайлан

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

